# НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
# ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 01 өдөр Дугаар А/94 Улаанбаатар хот

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, тусгай зөвшөөрлөөс чиглэл хасах, чиглэл нэмэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн Зургадугаар бүлгийн 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3.1, 19.3.4, 19.5.3, 19.21, 19.23 дахь хэсэг, Эрүүл мэндийн газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн яам төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 2/1126 дугаартай чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдүүдийг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн тусгай зөвшөөрлийн комиссын хуралд танилцуулсны дагуу Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох эмийн сангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх 1 хуулийн этгээдийн жагсаалтыг нэгдүгээр, эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ эрхлэх 9 хуулийн этгээдийн жагсаалтыг хоёрдугаар, тусгай зөвшөөрлөөс чиглэл хасах 2 хуулийн этгээдийг гуравдугаар, тусгай зөвшөөрөлд чиглэл нэмэх 1 хуулийн этгээдийн жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус батлсугай.

2.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хууль тогтоомж, стандартад нийцүүлэн үзүүлж, эмч, мэргэжилтний чадавхийг сайжруулан, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахыг хуулийн этгээдэд үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтад заасан эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгож, харьяа дүүргийн татварын байгууллагад мэдэгдэн, мэдээллийг цахим хуудаст байршуулахыг Захиргаа, нэгдсэн удирдлагын хэлтсийн дарга (У.Бат-Очир)-д үүрэг болгосугай.

4.Тусгай зөвшөөрөл авснаас хойш үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Б.Батцоож)-т, тайлан, мэдээг хууль, журмын дагуу хүлээн авч нэгтгэн, дүн шинжилгээ хийх, шинээр тусгай зөвшөөрөл олгогдсон эрүүл мэндийн байгууллагын мэдээллийг газрын тайлан мэдээний санд оруулж, баяжуулалт хийн ажиллахыг Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Д.Сайнхүү)-д тус тус даалгасугай.

1526010343

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, нэгдсэн удирдлагын хэлтсийн дарга (У.Бат-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГА Н.НАРАНБААТАР

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 05 дугээр сарын 01 -ны өдрийн
А/94 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЭМИЙН САНГИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

| д/д | Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /Регистрийн дугаар/ | Тусгай зөвшөөрлийн төрөл | Тусгай зөвшөөрлөөр эзэмших үйлчилгээний чиглэл | Хаяг |
|---|---|---|---|---|
| 1. | Энто фарм ХХК /6590233/ | Эмийн сан | Хоёрдугаар зэрэглэлийн эмийн сан | Сүхбаатар дүүргийн 1-р хороо, 13-р хороолол /14230/, нарны зам гудамж 89 барилга, 1 давхарт |
| 2. | Энто фарм ХХК /6590233/ | Эмийн сан | Хоёрдугаар зэрэглэлийн эмийн сан | Баянзүрх дүүргийн 6-р хороо, 62-р байр 46 тоот |

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 05 дугээр сарын 01 -ны өдрийн
А/94 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ЭМНЭЛГИЙН МЭРГЭШСЭН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР
ОЛГОХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

| д/д | Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /Регистрийн дугаар/ | Тусгай зөвшөөрлийн төрөл | Тусгай зөвшөөрлөөр эзэмших үйлчилгээний чиглэл | Хаяг |
|---|---|---|---|---|
| 1. | Ану оюу гэрэлтэх од ХХК /7081721/ | Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ | Дотрын өвчний тусламж, үйлчилгээ, Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ | Баянзүрх дүүргийн 26-р хороо, Глобал парк барилгын үйлчилгээний 2 дугаар давхарт 2 тоот |
| 2. | Манчим ХХК /2303965/ | Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ | Эмэгтэйчүүдийн өвчний тусламж, үйлчилгээ, Лабораторийн тусламж,үйлчилгээ /Клиник хими, Гематологи, Биохими, Молекул биологи/ | Хан-Уул дүүргийн 6-р хороо, Ярмаг, Наадамчдын гудамж 197 байр Ярмаг тауэр 6-р давхар 602-4 тоот |
| 3. | Гэрэлт айк дент ХХК /72412418 | Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ | Шүдний өвчний тусламж, үйлчилгээ /оношилгоо, эмчилгээ, шүдний өвчний согог, гажиг засал/ | Сүхбаатар дүүргийн 9-р хороо, Алтайн гудамж, 281-202 тоот |
| 4. | Их үсүй ХХК /7151809/ | Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ | Арьсны өвчний тусламж, үйлчилгээ | Сүхбаатар дүүргийн 1-р хороо, 13 Нарны зам гудамж, 56 тоот ЦОМА оффис 2-р давхарт |
| 5. | Асури таньюхан ХХК /7196289/ | Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ | Арьсны өвчний тусламж, үйлчилгээ | Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Б.Чимидийн гудамж, 41/1 Риюер кастл төвийн 6-р давхарт 622 тоот |
| 6. | Гоо тайж ХХК /6400779/ | Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ | Шүдний өвчний тусламж, үйлчилгээ /оношилгоо, эмчилгээ, шүдний өвчний согог, шүдний өвчний мэс засал/ | Сүхбаатар дүүргийн 2-р хороо, 5 хороолол, Сөүлийн гудамж, 10/2 байр, 303 тоот |
| 7. | БАМНА Эрдэнэс ХХК /7111225/ | Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ | Арьсны өвчний тусламж, үйлчилгээ | Баянгол дүүргийн 15-р хороо, Хасбаатарын гудамж, 3-р хороолол, 32А тоот |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8. | Элабора групп ХХК /7217081/ | Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ | Лабораторийн тусламж, үйлчилгээ /Гематологи, биохими, иммунологи, клиник хими, молекул биологи, нян судлал/ | Хан-Уул дүүргийн 20-р хороо, Үйлдвэр /17043/, чингисийн өргөн чөлөө гудамж, 75/1 барилга М1 тауэрийн 17 давхар 1704 тоот, 1705 тоот |
| 9. | Метеора ХХК /6936253/ | Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ | Шүдний өвчний тусламж, үйлчилгээ /оношилгоо, эмчилгээ, шүдний өвчний согог, гажиг,шүдний өвчний мэс засал/ | Баянзүрх дүүргийн 1-р хороо, 12-р хороолол, Токиогийн гудамж, GC центр 3 давхарт |

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 03 дугээр сарын 01 -ны өдрийн
А/94 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛӨӨС ЧИГЛЭЛ ХАСАХ
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

| д/д | Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /регистрийн дугаар/ | Тусгай зөвшөөрлийн төрөл | Тусгай зөвшөөрлөөс хасах чиглэл | Үндэслэл |
|---|---|---|---|---|
| 1. | Неон гялбаа ХХК /5395585/ | Арьс, Мэс заслын өвчний оношилгоо эмчилгээ, Шүдний өвчний оношилгоо эмчилгээ, согог засал /ЭХ-21/22/4332/ | Шүдний өвчний оношилгоо эмчилгээ, согог засал | Өөрийн хүсэлтээр |
| 2. | Цаглашгүй дэлгэр ХХК /5499283/ | Дотрын өвчний оношилгоо, эмчилгээ, Гоо сайхны пластик мэс засал | Гоо сайхны пластик мэс засал | Хурлын шийдвэр |

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 05 дугээр сарын 01 -ны өдрийн
А/94 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

9025101255 CTC6091 9077456

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД ЧИГЛЭЛ НЭМЭХ
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

| д/д | Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /регистрийн дугаар/ | Одоо эрхэлж буй үйл ажиллагааны чиглэл | Тусгай зөвшөөрөлд нэмэх чиглэл | Тусгай зөвшөөрлийн дугаар |
|---|---|---|---|---|
| 1. | Интеллиженс дент ХХК /6126413/ | Нүүр амны өвчний оношилгоо, эмчилгээ, согог, мэс засал | Шүдний өвчний гажиг засал | ЭХ-18/22/4006 |